



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/375

Мандалговь

Бэлэг дурсгалын зүйл авахад
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн бэлэг дурсгалын зүйлд зориулан Өлзийт сумын уугуул Монгол Улсын Ардын жүжигчин А.Нэргүйн “Энх мэндийн баяр” дууны шинэ цомог, Гурвансайхан сумын уугуул ЗХУ-ын Нийгмийн ухааны Академийн аспирант, Ардын дуу судлаач С.Батмөнхийн “Монгол ардын дууны тайлбарт дээж бичиг” номыг авахад хөрөнгө гаргасугай.

Хоёр. Бэлэг дурсгалын зүйл авах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Ном, цомог авахад шаардагдах 5000000 (Таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191063

Аймгийн Засаг даргын 2019 оны
10 дугаар сарын 21-ны өдрийн 1375 дугаар
захирамжийн хавсралт



БЭЛЭГ ДУРСГАЛЫН ЗҮЙЛ АВАХ ТӨСӨВ

Д/д	Зардлын утга	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	"Энх мэндийн баяр" дууны цомог	50	20000	1000000
2.	"Монгол ардын дууны тайлбарт дээж бичиг" ном	200	20000	4000000
	ДҮН			5000000